

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр, Пүрэв гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>2-3</i>

---

1. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	2-3
-----------------------------------------------------------------------------------------	-----

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы  
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны  
08 дугаар сарын 15-ны өдөр /Пүрэв гараг/-ийн хуралдааны  
товч тэмдэглэл**

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 13 цаг 00 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Д.Ганбат, Н.Наранбаатар;  
Тасалсан: Н.Номтойбаяр.

**Нэг. “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, референт Б.Гандиймаа нар байлцав.

Байнгын хорооны дарга Г.Тэмүүлэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс саналаа ирүүлээгүй тул “Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх асуудлыг хойшлуулах талаар мэдэгдэв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр үг хэлэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 24 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 87.5 хувийн ирцтэйгээр 13 цаг 05 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:  
АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Г.ТЭМҮҮЛЭН

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ  
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 15-ны өдөр,  
Пүрэв гараг  
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим,  
13 цаг 00 минут

### БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Г.Тэмүүлэн:** Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ингээд та бүхэнд Байнгын хорооны гишүүдийн ирцийг танилцуулъя.

Оюунсайханы Алтангэрэл,  
Наранцэцэгийн Алтаншагай,  
Чинбаатарын Анар, Энхтайваны Бат-Амгалан,  
Батын Батбаатар,  
Нацагдоржийн Батсүмбэрэл, Энхбатын Болормаа,  
Дашдондогийн Ганбат орон нутагт байна. Борхүүгийн Дэлгэрсайхан ирсэн байна. Хажсекберын Жангабыл, Батбаярын Жаргалан ирсэн байна. Пүрэвжавын Сайнзориг, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Пүрэвсүрэнгийн Наранбаяр, Өлзийхүүгийн Шижир, Баттөмөрийн Энхбаяр, Жадамбын Энхбаяр, Лутаагийн Энхнасан, Сүхбаатарын Эрдэнэболд, Равжихын Эрдэнэбүрэн нар хүрэлцэн ирснээр өнөөдрийн Байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн байна.

Ингээд 2024 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Хэлэлцэх асуудал I асуудал байгаа.

Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүний асуудлыг хэлэлцэх асуудал байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурлын дэгийн хуралдаанаар дэгийн тухай хуулиар холбогдох Улсын Их Хурал дахь бүлгүүд бас тухайн дэд хороонд, Тусгай

хяналтын дэд хороонд оруулах бүрэлдэхүүндээ албан ёсоор бичгээр саналаа ирүүлэх ёстой байгаад байгаа. Үүнтэй холбоотойгоор бас сая Монгол Ардын намын бүлэг болон Улсын Их Хурал дахь Ардын намын бүлгээс ...

Би бас ирцэд ороогүй байсан байна. Орчихъё.

Бүлгээс албан ёсоор ингээд хүсэлтээ ирүүлэх ёстой байгаад байгаа, Улсын Их Хурлын даргад. Одоогийн байдлаар Монгол Ардын намын бүлгээс саналаа ирүүлсэн байгаа. Ардчилсан намын бүлгээс албан ёсоор саналаа ирүүлээгүй. Улсын Их Хурлын даргаас цохолт ирээгүй байгаад байгаа. Үүнтэй холбогдуулж бас сая даргын дэргэдэх зөвлөл дээрээс чиглэл гаргаж, манай энэ Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнийг хэлэлцэх энэ асуудлыг дараагийн 7 хоног хүртэл буюу Ардчилсан намын бүлгээс, бүлгийн даргаас албан ёсоор бичгээр санал нь ирэх хүртэл хойшлуулах саналыг бас гаргасан байгаа.

Энэ дагуу өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг хойшлуулах саналтай байна.

Ж.Энхбаяр гишүүн саналтай байна. Ж.Энхбаяр гишүүний микрофоныг өгье.

**Ж.Энхбаяр:** Би гишүүддээ хандаж, нэг хэдэн үг хэлэх гэсэн юм. Энэ Тусгай хяналтын дэд хороо гэдэг маань өөрөө Улсын Их Хурлын их онцгой чиг үүргүүдийн нэг. Улс орны хэмжээнд явагдаж байгаа гүйцэтгэх ажиллагааны мэдээлэл, маш нууц төслүүд, түүний санхүүжилт, хэрэгжилт гээд олон зүйл дээр яг гар бие оролцдог ийм дэд хороо.

Тэгэхээр энд олон гишүүд орох хүсэлтэй байгаа байх. Тэгэхээр бодлогоор ер нь энэ дэд хороог ер нь цөөн хүнээр бүрдүүлэх ёстой байдаг. Энэ дээр Байнгын хорооны даргад анхаараач ээ,

тоог битгий өргөтгөөрэй. Яагаад гэвэл 126 болсонтой холбогдуулаад бусад дэд хороотой адилхан тоог өргөтгөх нь өөрөө улс орны аюулгүй байдалд бас эмзэг байдлыг нэмэгдүүлнэ гэж миний санал шүү. Үүнийг цаашаа уламжлахыг хүсэж байна.

2 дугаарт, энэ түр хорооны гишүүн болсноор гишүүн таны ажил, амьдрал, гэр бүл, үр хүүхэд, харилцагч ах дүүс, бизнес, улс төрийн бүхий л ажил давхар хяналтад ордог гэдгийг гишүүд маань сайн ухамсарлаарай. Гадаад, дотоод явах, бүх үйл хөдөлгөөн чинь заавал энэ хариуцсан референтүүдэд бүртгүүлж, хөдөлгөөнөө мэдүүлж, ер нь давхар давхар л ийм байдаг. Нэг тийм, нэг талдаа хүсээд байх зүйл ердөө биш байдаг юм шүү. Их болгоомжтой байхгүй бол хөдөлгөөн чинь хязгаарлагдана, гадаад, дотоод явах, зорчих олон газраар бас хязгаарлагдана. Уулзах уулзалтын дараа заавал тайлбар, тайлан, протоколын юмнууд орж ирдэг. Гэр бүл, үр хүүхдийн чинь ажил, хөдөлгөөн бас давхар хяналтад ордог гэдгийг бас нэг сайн бодолцоорой.

Тэгээд олон улсууд бас сонирхоод байж магадгүй. Тэгэхээр энд бол аль болох парламентад удсан, туршлагатай, ер нь тусгай албаны шалгалтаар нэлээн сайн шүүгдчихсэн ийм улс төрчид ер нь байж ирсэн уламжлалтай байдаг юм шүү гэдгийг бас нэг хэлэхийг хүсэж байна.

Тоог болл бусад Байнгын хороод харахад нэг 10-аас дээш, 11, хоёр, гурав хийгээд байх шиг байна. Үүнийг л яг тоог багасгаарай. Болж өгвөл нэг 5. Болохгүй байна гэхэд нэг 7-оос битгий хэтрүүлээрэй л гэдгийг бас хэлэхийг хүсэж байна.

**Г.Тэмүүлэн:** Ойлголоо. Тэгэхээр Улсын Их Хурлын тухай хуулиар угаасаа энэ Байнгын хороо болоод дэд хорооны бүрэлдэхүүний асуудлаар Улсын Их Хуралтай зөвшилцөх гэж энэ Улсын Их

Хурал дахь намын бүлгийн бүрэн эрхийг тогтоож өгсөн байгаад байгаа.

Тэгэхээр энэ дээр 2 намын бүлгүүд өөрсдөө тодорхой бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж, албан бичгээр саналаа ирүүлэх байгаад байгаа.

Ингээд энэ Тусгай хяналтын дэд хорооны бүрэлдэхүүнийг хэлэлцэх асуудлыг тодорхой албан ёсны саналууд ирэх хүртэл ингээд тодорхойгүй хугацаагаар хойшлуулж байна.

Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдааныг хойшлуулж байна.

13.05 цаг

Гишүүддээ баярлалаа.

**ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ**

**П.ОЮУНГЭРЭЛ**